



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 61

Баруун-Урт

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. 2019-2025 онд хэрэгжүүлэх аймгийн “Соёл урлагийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол соёл урлагийн газар /Л.Байгалмаа/, Угсаатны зүйн музей /Д.Ариундэлгэр/, “Жаахан шарга” театр /Г.Баярцогт/, Нийтийн номын сан /Х.Мөнгөн-Өлзий/ нарт даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралд тайлагнаж байхыг Аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.



СҮХБААТАР АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Киноны тухай хууль, Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, “Сонгодог урлаг” үндэсний хөтөлбөр, Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр, “Чулуун соёл” хөтөлбөр, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, аймгийн соёл, урлагийн салбарын байгууллагуудын өнөөгийн байдал, хүрсэн түвшин зэрэг нь орон нутагт соёл урлагийн талаар тодорхой баримтлах бодлоготой байхыг шаардаж байгаа юм.

Угсаатан ястны онцлогтой соёл урлаг, ардын өв уламжлал, биет болон биет бус өв, ёс заншил, соёлын онцлог хэв шинжийг хайрлан хамгаалах, өвлөн уламжлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсад сурталчлан таниулах, орчин үеийн болон сонгодог урлагийн дэлхий нийтийн хөгжлөөс хоцрохгүй хөгжүүлэх нь нь соёл урлагийн салбарын гол зорилт болж байна.

Энэхүү нөхцөл байдлаас үүдэн Сүхбаатар аймгийн соёлын салбарыг чигч удирдлагаар ханган, хөрөнгө оруулалтын зөв зохистой бодлого хэрэгжүүлэх, соёл урлагийн байгууллагуудын боловсон хүчний мэдлэг боловсрол, ур чадвар, нийгмийн асуудлыг сайжруулах, барилга байгууламжинд эрэмбэ дараатайгаар засвар үйлчилгээ хийх, өргөтгөх, шинээр барих, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, жижиг хэрэглэлээр хангах, шинэчлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго

Монгол улсын үндсэн хууль, Соёлын тухай холбогдох хууль, дүрэм журам, төрөөс соёлын талаар хэрэгжүүлэх бодлого чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн соёлын байгууллагуудыг бүх талаар чадавхижуулах, бэхжүүлэх, соёл урлаг хөгжих таатай орчин нөхцөл бүрдүүлэх, соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх

2.2 Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Соёл, урлагийн салбарын менежмент, эдийн засаг, санхүү хөрөнгө оруулалтыг оновчтой болгох

Зорилт 2. Мэргэжлийн урлаг, соёлын байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Зорилт 3. Соёлын өвийг бүртгэх, эрэн сурвалжлах, хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчилах

Зорилт 4. Угсаатны онцлогийг харуулсан соёл олон нийтийн үйл ажиллагааг дэмжин, дэлгэрүүлэх

Зорилт-5. Монгол Улсын соёлын үнэт өв, үндэсний тусгаар тогтолын бэлгэ тэмдгийн нэг болох Монгол адуу дагасан биет бус соёл уламжлалыг хамгаалан, улмаар түгээн дэлгэрүүлж, Сүхбаатар аймгийг "Монгол адууны өв соёлын төв" болгоно

Гурав. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1-ын хүрээнд

3.1.1 Соёлын төвүүдийн барилгыг эрэмбэлэн, дарааллын дагуу шинээр болон өргөтгөн барих, их засвар хийх ажлыг хийнэ. Мөнххаан, Халзан, Түвшинширээ, Уулбаян сумдад шинэ соёлын төв барина. Асгат сумын Соёлын төвийг хуучин сургуулийн барилгад шилжүүлэн их засвар хийнэ.

3.1.2. Аймгийн төвд музей, номын сан, соёлын төв бүхий цогцолбор байгуулна.

3.1.3. "Хүүхдийн ордон" байгуулж хүүхдүүдийн авьяас чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх дугуйлан секц хичээллүүлнэ.

3.1.4. Технологийн шаардлага хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, өндөр хурдны интернет, дуу, дүрс бичлэгийн студи, камержуулалт, дохиолол хамгаалал, хөгжим, гэрэлтүүлгээр соёл урлагийн байгууллагуудыг дэс дараатайгаар хангана.

3.1.5. Соёл, урлагийн салбарын дотоод, гадаад харилцааг өргөжүүлж хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

3.1.7. Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас жил бүр тодорхой хэмжээний зардлыг төсөвлөн соёлын салбарын хөрөнгө оруулалтанд зарцуулна.

3.1.8. ХЭКТ-ын эрх зүйн орчныг сайжруулж, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, санхүүгийн менежментийг шинэчилж бусдаас хараат бус байх нөхцлийг бий болгож эхэлнэ.

3.1.9 Соёлын байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчинээр хангах бодлого барьж, шаардлагатай мэргэжлээр ажиллаж байгаа оюутныг дэмжин суралцуулах, ажлын байраар хангах, хүний нөөцийг чадваржуулах, дахин сургах тогтолцоог бүрдүүлнэ.

Үр дүн:

Нэг. Соёл урлагийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаа тасралтгүй явагдах шаардлага хангасан техник хэрэгсэл тоног төхөөрөмж бүхий барилга байгууламж, орчин нөхцөл бүрдэнэ.

Хоёр. Соёл урлагийн байгууллагууд мэргэжлийн боловсон хүчинээр хангагдана

Зорилт 2-ын хүрээнд

3.2.1. Соёл урлагийн байгууллагууд иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйл ажиллагааг байнга шинээр санаачилан соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, хандлагыг өөрчилнө.

3.2.2. Захиалгат уран бүтээлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх замаар зорилтот үйлчилгээг бий болгоно.

3.2.3. ХЖТ-ыг олон улсын стандартад нийцсэн, дуу, шум, гэрлийн тоног төхөөрөмжөөр ханган, эргэдэг тайзтай болгож, гадаад дотоод орчинг нутгийн онцлог байдлыг харуулсан заслаар тохижуулна.

3.2.4 Музейгүй сумдад орон нутаг судлах танхим /музей/ байгуулж, музейн сан хөмрөгийг баяжуулах, үзмэр худалдан авах, соёлын биет болон биет бус өвийг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.2.5. Театр, музей, номын сан, соёлын төвүүдийн үйлчилгээний чанарт анхаарч гадаад дотоод орчинг сайжруулан утгах, үйлчлэх орчин нөхцөл, ажилчдын харилцаа, ёс зүйд шинэчлэл хийнэ.

3.2.6. Соёлын төвийн номын санг сургалт мэдээлэл, танин мэдэхүйн төв болгон ажиллуулж, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

3.2.7. Шинээр хэвлэгдсэн ном бүрийг номын сан болгонд хүргэдэг шинэлэг менежментийг бүрдүүлнэ.

3.2.8. Явуулын номын сан, цахим номын үйлчилгээг орчин үеийн шаардлага хангасан хэлбэрээр хүргэж эхэнэ.

3.2.9. Сум бүрт дэс дараатайгаар кино цэг байгуулна.

3.2.10. Нүүдлийн театр байгуулж хөдөөгийн хүн амд хүрч үйлчилнэ.

3.2.11. "Шилдэг Соёлын төв" шалгаруулах ур чадварын уралдааныг 3 жилд нэг удаа зохион байгуулна.

Үр дүн:

Нэг. Соёлын байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмж сайжирна
Хоёр. Үйл ажиллагааны төрөл хэлбэр, цар хүрээ нэмэгдэнэ.

Гурав. Иргэн бүр соёлын үйлчилгээ хүртэнэ.

Зорилт 3-ын хүрээнд

3.3.1. Соёлын өвийн бүртгэлийг шинэчлэн, сум бүрт мэдээллийн сан бүрдүүлж, ажиллах хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.

3.3.2. Соёлын биет бус өв тээгчдийг илрүүлэх, өвлүүлэх, сурталчлах ажлыг жил бүр зохион байгуулж 3 жилд нэг удаа "Өвийн наадам" зохион байгуулна

3.3.3. Соёлын биет өвийг шинээр судлан, хадгалалт хамгаалалтын менежментийг сайжруулан, шаардлагатай үл хөдлөх хөшөө дурсгалыг зориулалтын музей танхимд байрлуулах, хуулбарыг тухай орчинд нь бий болгох ажлыг эхлүүлнэ.

3.3.4. Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтанд авах, тэдгээрийг эдийн засгийн эргэлтэнд оруулж, сэргээн засах ажлыг зохион байгуулна.

3.3.5 Түүх соёлын дурсгалыг хамгаалсан, зөрчлийг илрүүлсэн, таслан зогсоосон, мэдээлсэн иргэн, аж ахуй нэгжийг урамшуулна.

3.3.6 Устаж үгүй болох эрсдэлтэй соёлын өвийг баримтжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, баримтжуулж, сан хөмрөгт хадгална.

3.3.7 Угсаатны зүйн музейг орчин үеийн шаардлага хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, шум, гэрэлтүүлэг, дохиоллын системээр хангана.

3.3.8 Угийн бичиг хөтлөлтийн судалгааг жил бүр бодитой, шаардлага хангасан хэмжээнд гаргаж, угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх ажлыг сум бүр шинэлэг аргаар зохион байгуулж үр дүнд хүрсэн байна.

Үр дүн:

Нэг. Соёлын өвийн бүртгэл мэдээлэл сайжирна.
Хоёр. Соёлын өвийн хадгалалт хамгаалалт нэмэгдэнэ.
Гурав. Угийн бичиг хөтлөх айл өрхийн тоо нэмэгдэнэ.

Зорилт 4-ын хүрээнд:

- 3.4.1. Дарьганга, үзэмчин, хатиган, хуучид болон бусад угсаатны өв соёлыг сурталчлах, хадгалан үлдээх зорилтын хүрээнд эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулна.
- 3.4.3. Нутгийн ардын дуу, хуур, бүжиг наадмыг хүүхэд залууст сургах, ахмад, залуучууд, хүүхдийн байгууллага, хөдөлгөөний үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.4.4. Угсаатан судлалын ажлыг эрчимжүүлж, эрдэмтэд судлаачид, уран бүтээлчид, иргэдийн үйл ажиллагааг дэмжсэн арга хэмжээнүүд зохион байгуулна
- 3.4.5. Дарьганга мөнгөн урлал, сийлбэр урлалыг өвлүүлэн уламжлуулах, хүүхэд залуучуудад зааж сургах талаар тодорхой ажлууд зохион байгуулна.

Үр дүн:

Нэг. Угсаатны бүлгүүдийн талаарх судалгааны ажлууд хийгдэнэ
Хоёр. Нутгийн угсаатны онцлог бүхий соёлын өвүүд хадгалан үлдэнэ.
Гурав. Уламжлалт гар урлалын үйлдвэрлэлийг өвлөн авч үлдэхээс гадна, соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжинө.

Зорилт 5-ын хүрээнд:

- 5.1. Монгол адууны адуулга маллагаа, адуутай холбоотой эд хэрэгсэл, соёл уламжлалыг үндсэн шинжээр нь өвлөн хадгалах, түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх,
- 5.2. Хил орчмын аялал жуулчлалын маршрутын дагуу бүс, улс, олон улсын түвшинд монгол адууг сурталчлан таниулах, монгол цусны адууны уралдаан, олон талт үйл ажиллагаа зохион байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлэх.
- 5.3. Адууны адуулга маллагаа, адуучны ур чадвар эзэмшсэн хүнийг соёлын биет бус өв, өв тээгчээр тодруулан улсын хэмжээнд сурталчилан таниулах
- 5.4. "Адууны нутаг Дарьганга" сэдвийн хүрээнд бүтээгдэж буй бүхий л урлагийн бүтээлүүдийг дэмжин, брэнд бүтээгдэхүүнтэй болох
- 5.5 "Агтана хүрээт" эвент арга хэмжээний хүрээнд адууны өв соёл, угсаатан, ясны хувцас хэрэглэлийн үзэсгэлэн, хэрэглээний талаар тодорхой арга хэмжээнүүд зохион байгуулах

Үр дүн:

Нэг. Монгол адууг цэврээр нь авч үлдэх, өсгөх тал дээр ахиц гарна.
Хоёр. Адуутай холбоотой уламжлалт өв соёл өвлөгднө.
Хоёр. Адуутай холбоотой арга хэмжээнүүдээр дамжин тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжихөөс гадна мал аж ахуйгаар дамжин орон нутгийн эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ.